



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 534

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион  
байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 46,866,001.23 (дөчин зургаан сая найман зуун жаран зургаан мянга нэг төгрөг хорин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001323

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

534

"МОНГОЛПРОСЦЕВМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины марк, улсын<br>дугаар, арал                                                                                      | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ<br>(төгрөг)                                                                                          | Хуризмтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                | Үлдэх өртөг<br>(төгрөг) | ТӨБЗГ-ын 2019 оны<br>395 дугаар<br>тогтоолоор<br>тогтоосон доод үнэ<br>(төгрөг) | Шинэчлэн<br>тогтоосон<br>худалдах доод үнэ<br>(төгрөг) | Дэнчингийн хэмжээ<br>(төгрөг)                                 |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------|---------------------------------------------------------------|
| 1   | Суудлын автомашин BMW<br>(Москва дахь Төлөөлөгчийн<br>газар), улсын дугаар<br>089D163778, арлын дугаар<br>WBANU110X0CW41408 | 2006/2007                               | 46,866,001.23                                                                                                     | 46,866,001.23                                                                                                     | 0.00                    | 10,000,000.00                                                                   | 5,000,000.00                                           | 1,250,000.00                                                  |
|     | НИЙТ ДҮН                                                                                                                    |                                         | 46,866,001.23<br>(дөчин зургаан<br>сая найман зуун<br>жаран зургаан<br>мянга нэг төгрөг<br>хорин гурван<br>мөнгө) | 46,866,001.23<br>(дөчин зургаан<br>сая найман зуун<br>жаран зургаан<br>мянга нэг төгрөг<br>хорин гурван<br>мөнгө) |                         | 10,000,000.00<br>(арван сая төгрөг)                                             | 5,000,000.00<br>(таван сая төгрөг)                     | 1,250,000.00 (нэг<br>сая хоёр зуун<br>тавин мянган<br>төгрөг) |